ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 09 өдөр Дугаар А/75 Даланзадгад

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/294 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулах үлгэрчилсэн журам"-ыг нэгдүгээр, "Түргэн тусламжийн үйлчилгээнд хэрэглэгдэх эм, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт"-ыг хоёрдугаар, "Болзошгүй гамшиг, олныг хамарсан ослын үеийн эрэмбэллийн заавар"-ыг гуравдугаар, "Түргэн тусламж, үйлчилгээний эргэн мэдээлэх тайлангийн маягт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.
2. Тушаалын хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжилтийг хангаж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж үнэлгээ дүгнэлт гаргаж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга /Б.Мидэрсүрэн/-д, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /Ж.Отгонбайгал/-д тус тус даалгасугай.

ДАРГА Ц.ӨНӨРЖАРГАЛ

4619207282
ТУ31732 9047751

C:\ Desktop\2020 on TUSHAAL

461200193

ТУШААЛЫН ТАНИЛЦУУЛГА

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд түргэн тусламжийн үйлчилгээг:

Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ гэж тодорхойлсон.

Хуулийн 11 дүгээр зүйлээр түргэн тусламжийн үйлчилгээг дараах байдлаар зохион байгуулахыг заасан.

11.1.Түргэн тусламжийн үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий түргэн тусламжийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг үзүүлнэ.

11.2.Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн болон тухайн чиглэлээр сургагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн баг үзүүлнэ.

11.3.Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчлэх хүрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

Тусламж, үйлчилгээг өмнө зохицуулж байсан журмууд:

- 2012 оны а/217- НЭМГ, "Түргэн тусламжийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" ,
- 2014 оны а/292- ЭМС, Нийслэлийн Хан-уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй, Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэлд түргэн тусламжийн нэгж байгуулж 2014 оны 10 дугаар 01-ээс үйл ажиллагааг нь эхлүүлэхийг НЭМГ-т,
- 2016 оны а/91- ЭМС, Энэ тушаалыг хүчингүй болгосон.
- 2010 оны 7 дугаар сарын 7-ны 42/123/246- МУ-ын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэрэг, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал: Нийслэлийн цагдаагийн газрын ШУТ, ОБЕГ-ын Гамшигтай тэмцэх газар, Нийслэлийн онцгой байдлын газрын шуурхай удирдлага, зохицуулалт хариуцсан зарим нэгж, Нийслэлийн яаралтай тусламжийн төвийн зохицуулагч, оператор, инженерийн албадыг нэгтгэн бүтэц, орон тоог баталж, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвийг байгуулсан. /101,102,103,105/
- 2016 оны 01 дүгээр сарын а/01- НЭМГ-ын даргын тушаал "Түргэн тусламж, үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай"
- 2016 оны 11 дүгээр сарын а/106- НЭМГ-ын даргын тушаал "Түргэн тусламж, үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай"

Түргэн тусламж, үйлчилгээг НЭМГ-ын хүрээнд зохицуулах хууль эрхийн зохицуулалттай байсныг хуульд заасан ЭМБ-ууд үзүүлэх үед баримтлах журам, заавар байдлаар боловсруулагдсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
а/75 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх үйлчилгээг түргэн тусламжийн үйлчилгээ гэнэ.

1.2. Түргэн тусламжийн үйлчилгээг үйлчлүүлэгчид хамгийн ойр байгаа тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн эмнэлэг, үзүүлнэ.

1.3. Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн болон тухайн чиглэлээр сургагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн баг холбогдох эмнэл зүйн заавар, удирдамжийг баримтлан үзүүлнэ.

1.4. Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх журмыг энэхүү журам болон холбогдох бусад хууль, эрх зүйн хүрээнд тусламж, үйлчилгээнийхээ өвөрмөц онцлогт нийцүүлэн баталж, мөрдөж ажиллана.

1.5. Түргэн тусламжийн үйлчилгээнд Эрүүл мэндийн сайдын А/611 дугаар тушаалын эрүүл мэндийн бүртгэлийн СТ-23А (түргэн тусламжийн дуудлагын хуудас); СТ-23Б (хүүхдийн түргэн тусламжийн дуудлагын хуудас) болон СТ-33; СТ-36; АМ-33 ... маягтуудыг хөтөлнө.

1.6. Эрүүл мэндийн байгууллага нь болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед түргэн тусламжийн шуурхай, бэлэн байдлыг хангаж ажиллана.

ХОЁР. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

1.1. Үйлчлүүлэгчийн эрх, аюулгүй байдлыг дээдэлнэ.

1.2. Хүнлэг энэрэнгүй байна.

1.3. Шашин шүтлэг, үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн байдал, гарал, үүслээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид байна.

1.4. Тусламж, үйлчилгээний бэлэн, шуурхай, аюулгүй байдлын зарчмыг баримтална.

1.5. Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм, хэмжээг чанд баримтална.

ГУРАВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Эрүүл мэндийн байгууллага нь иргэд, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эмнэлгийн анхан болон амилуулах суурь тусламжийн мэдлэг олгох, чадавхжуулах сургалт явуулах нийтлэг үүрэгтэй.

3.2. Эрүүл мэндийн байгууллага нь хүчин чадал, нөөц боломжид үндэслэн агаарын тээврийн зориулалтын талбайтай, агаарын тээврийн хэрэгслээр түргэн тусламж үзүүлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэн ажиллаж болно.

3.3. Байгууллагын түргэн тусламжийн үйл ажиллагааны журамд дараах нийтлэг зохицуулалтыг тусган хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1. Түргэн тусламжийн үйлчилгээ нь 24 цагийн бэлэн байдлыг хангасан, түргэн тусламжийн дуудлага зохицуулагч (цаашид дуудлага зохицуулагч гэх), тусламж, үйлчилгээг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэх мэргэшсэн дуудлагын баг (цаашид дуудлагын баг гэх)-тай байна.

3.3.2. Дуудлага зохицуулагч нь дуудлага хүлээн авч, бүртгэж, мэдээлэх, багийг хуваарилах үүрэг бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн байна.

3.3.3. Дуудлагын багийн үндсэн үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчид шаардлагатай тусламжийг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад багийн зохион байгуулалтаар үзүүлэн яаралтай тусламжийн нэгжид хүлээлгэн өгөх үйл ажиллагаа болно.

3.3.4. Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учрах эрсдэлтэй тохиолдолд холбогдох эмнэлгийн яаралтай тусламжийн нэгжид тээвэрлэх явцад мэдэгдэн, бэлэн байдлыг хангуулж, гараас гарт хүлээлгэн өгнө.

3.3.5. Дуудлагын баг нь түргэн тусламжийг газар дээр нь болон, тээвэрлэлтийн явцад үзүүлэхдээ эмнэлгийн яаралтай тусламжийн эмч, зөвлөх эмч, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.3.6. Дуудлагын баг нь түргэн тусламжийн үйлчилгээнд холбогдох баримт бичиг, зөвшөөрөгдсөн бүртгэл, хяналтын хуудаснуудыг бүрэн хөтөлсөн байна.

3.3.7. Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг тогтмол авч ажиллана.

3.3.8. Дуудлагын багийг халдварын эрсдэл, цаг агаарын халуун, хүйтэн нөхцөл, химийн хорт бодис, бусад хүндрэлтэй нөхцөл байдалд ажиллах хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангасан байна.

3.3.9. Түргэн тусламжийн үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага ижил бүтэц, үүрэг, хариуцлага хүлээж оролцоно.

3.3.10. Бүртгэлтэй дуудлагаас бусад тохиолдолд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, дуудлага өгөх эрх бүхий албан тушаалтан, шийдвэр гаргах шатны байгууллагын гаргасан шийдвэрээс бусад тохиолдолд түргэн тусламжийн баг ажиллуулах, үзүүлсэн тусламж үйлчилгээтэй холбогдолгүй асуудлаар магадалгаа, дүгнэлт гаргах, зөвшөөрөгдөөгүй эмийн жор бичихийг түргэн тусламжийн үйлчилгээнд хориглоно.

ДӨРӨВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВТОМАШИН

4.1. Түргэн тусламжийн тээврийн хэрэгсэл гэж эмнэлгийн зориулалтын, байршил тогтоогч, яаралтай тусламжийн эм, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл болон богино долгионы холбооны хэрэгслээр тоноглогдсон, дуут дохиолол, таних тэмдэг бүхий туулах чадвар сайтай автомашиныг хэлнэ.

4.2. Түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн өнгө, дуут дохио, таних тэмдэг, тэмдэглэгээ нь дараах байдалтай байна.

4.2.1. Цагаан өнгөтэй, ногоон өнгийн тусгай дуут дохиотой байна.

4.2.2. Дуут дохионы нотыг MNS 4979:2016 стандартын дагуу тогтооно

4.2.3. Түргэн тусламжийн таних тэмдгийг автомашины хажуу хоёр тал, арын хаалга, дээд талд байрлуулна.

4.2.4. Таних тэмдгийн өнгө хөх –RGB – 0.0.255; шар -RGB – 255.255.0 кодтой байх ба 45 см х 45 см хэмжээтэй байна.

4.2.5. "ТҮРГЭН ТУСЛАМЖ" гэсэн тэмдэглэгээг автомашины урд (капот), хоёр хажуу талд байрлуулна.

4.2.6. Тэмдэглэгээ нь улаан-RGB -100.0.0 кодтой, урт нь 120 см, өндөр нь 12 см байна.

4.3. Түргэн тусламжийн автомашин нь үйлчлүүлэгчийг суугаа болон хэвтээгээр тээвэрлэх, эмч, эмнэлгийн ажилтан гардан үйлдэл хийхэд хүрэлцэхүйц талбай бүхий тээврийн хэрэгсэл байна.

4.4. Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламжийн автомашины ашиглалт, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шаардлагатай шинэчлэлийг хийж ажиллана.

4.5. Эрүүл мэндийн байгууллагууд түргэн тусламжийн автомашины хэрэглээнд халдварын сэргийлэлт, хяналтын журмыг баримтлан, хяналт тавьж ажиллана.

4.6. Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь холбогдох журамд заасан жолооч, автомашины аюулгүй ажиллагааны хяналтын хуудсыг хөтөлж, тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.7. Дуудлагын баг нь түргэн тусламжийн үйлчилгээнд гарахын өмнө болон дараа жолооч, автомашины аюулгүй ажиллагааны хяналтын хуудсыг хөтөлж хэвшүүлсэн байна.

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН ХАНГАЛТ

5.1. Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч, яаралтай тусламжийн эмч, мэргэжилтэн, жолооч нарын ажлын хувцаст тавигдах шаардлага нь Монгол улсын "Тусгай зориулалтын ажлын хувцасны стандарт" MNS 6231:2011 стандартад тусгагдсан үзүүлэлтийг баримтална.

5.2. Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч, яаралтай тусламжийн эмч, мэргэжилтэн, жолооч нарын ажлын хувцаст цамц, нимгэн өмд, хантааз, халад, дан хүрэм, дулаалгатай хүрэм, дулаалгатай өмд тус тус орно.

5.3. Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байна.

5.4. Цэвэрлэхэд хялбар, энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байна.

ЗУРГАА. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГЫН ТӨРӨЛ.

Дуудлага зохицуулагч түргэн тусламжийн дуудлагыг хүлээн авч, дараах байдлаар ангилан, холбогдох зохицуулалтыг хийнэ. Үүнд:

6.1. **Яаралтай дуудлага**. Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн нөхцөл байдалтай, эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн өгүүлэмжтэй бол дуудлага өгсөн байршилд 20 минутаас хэтрэхгүй хугацаанд тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх зохицуулалт хийнэ.

6.2. **Хүлээгдэлтэй дуудлага.** Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул занал учруулахуйц шинж тэмдэггүй бол 20-60 минутад тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг хийнэ.

6.3. **Дуудлагын алслагдмал байдлаас хамаарах дуудлагын төрөл:**

6.3.1. Ирүүлсэн дуудлага түргэн тусламж үзүүлэх багаас 25 км дотор байршилд бол ***ойрын дуудлага,***

6.3.2. Ирүүлсэн дуудлага 25 км-аас дээш алслагдсан байршилд бол ***холын дуудлагад*** бүртгэн, хүрч очих боломжит хугацааг тодорхойлж, дуудлага өгсөн иргэнд мэдэгдэн, дуудлагын баг очих хүртэл авах арга хэмжээний зөвлөгөө өгч, өгсөн зөвлөгөө, авсан арга хэмжээг дуудлагын хуудсанд тэмдэглэн холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авна.

ДОЛОО. ДУУДЛАГЫН ТӨРӨЛД ХАМААРАХ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ

7.1. **Яаралтай дуудлагад хамаарах хам шинж:**

7.1.1. Ухаангүй байдал
7.1.2. Бүх төрлийн осол гэмтлүүд
7.1.3. Зүрх судасны дутмагшил
7.1.4. Амьсгалын тогтолцооны дутмагшил
7.1.5. Бүх төрлийн оворго
7.1.6. Төрөлт болон жирэмслэлттэй холбоотой амь насанд аюул тулгарсан үед
7.1.7. Бүх төрлийн цус алдалт
7.1.8. Хүүхдийн яаралтай дуудлага /таталт, бачууралт, ухаангүй, маш өндөр халуурсан, халууралт таталт хавсарсан, бөөлжсөн, унтаарсан, уух буюу хөхөх чадваргүй, хөхөрсөн/
7.1.9. Цээж хэвлийн хүчтэй өвдөлтүүд
7.1.10. Бөөр шээсний замын хурц дутмагшил
7.1.11. Гадна орчны нөлөөллүүд /живэх, аянга, амиа хорлох оролдлого, хөлдөлт/
7.1.12. Бүх төрлийн хордлого
7.1.13. Их хэмжээний түлэгдэл
7.1.14. Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэг
7.1.15. Халдварт өвчнүүд

7.2. **Хүлээгдэлтэй дуудлагад хамаарах хам шинж:**

7.2.1. Харшлын байдал
7.2.2. Хэвлий, нуруу, цээжээр өвдөх
7.2.3. Бөөрний архаг өвдөлт
7.2.4. Бөөлжих

7.2.5. Арьс салстаар туурал гарах
7.2.6. Халуурах (эм уугаад буурахгүй)
7.2.7. Шээс гэнэт хаагдах
7.2.8. Ходоод гэдэсний хямрал
7.2.9. Насанд хүрэгч зан аашийн хэвийн бус үйлдэл гаргах
7.2.10. Хүүхдийн ааш зан гэнэт өөрчлөгдөх

НАЙМ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

8.1. **Бүсийн оношилгоо эмчилгээний төв:**

8.1.1. Яаралтай тусламжийн нэгж нь түргэн тусламжийн дуудлага зохицуулагч, дуудлагын багтай байна.

8.1.2. Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжаар мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн тухайн чиглэлийн сургалтад хамрагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн дуудлагын баг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэх бэлэн байдлыг хангаж, зохицуулж ажиллана.

8.1.3. Яаралтай тусламжийн нэгж нь дуудлагын багт зөвлөн туслах үүрэг гүйцэтгэх зохион байгуулалтыг журамдаа нарийвчлан тусгаж, амь тэнссэн үеийн дуудлагад тосч үйлчлэх бэлэн байдлыг хангаж ажиллана.

8.1.4. Дуудлагын баг нь аймаг, орон нутгийн нутаг дэвсгэр дээрх ойрын болон алсын дуудлагын тусламж, үйлчилгээг чанартай, шуурхай гүйцэтгэнэ.

8.1.5. Дуудлагын баг нь мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, стандартад заасан шаардлага хангасан дуудлага хүлээн авах утас, түргэн тусламжийн автомашин, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, байршил тогтоогч, бусад холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

8.1.6. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь баг, сумдаас ирсэн дуудлагын төрлөөс хамаарч бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс зөвлөх эмч дуудах, хүргэх асуудлаар шийдвэр гаргаж ажиллана.

8.2. **Сумын эрүүл мэндийн төв.**

8.2.1. Харьяалах болон түүний ойролцоо нутаг дэвсгэрт тохиолдсон гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үеийн түргэн тусламжийн үйлчилгээг иргэд, байгууллага, хувь хүний дуудлага, мэдээллээр харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлнэ.

8.2.2. Түргэн тусламжийн дуудлага, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч, анхан болон амилуулах суурь тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулах үүрэг хүлээнэ.

8.2.3. Түргэн тусламжийн ойрын болон алсын дуудлагын үйлчилгээг үзүүлэх байгууллагын журмыг энэхүү үлгэрчилсэн журам, стандарт болон холбогдох бусад хууль эрх зүйд нийцүүлэн баталж, хэрэгжүүлж ажиллана.

8.2.4. Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч нь ирсэн дуудлагын төрлөөс хамаарч түргэн тусламжийн жолооч, эмч болон багийн бага эмчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтын хувьд чиглүүлж, дэмжлэг үзүүлж ажиллана.

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
а/75 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ЭМ, БАГАЖ, ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

1.1. Түргэн тусламжийн автомашин нь эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслээр доор дурдсан тоо хэмжээгээр тоноглогдсон байна.

№	Эмнэлгийн хэрэгсэл	Хэмжих нэгж	Тоо ширхэг /энд зааснаас дээш тоотой/
1.	Хяналтын монитор /Цэнэглэх боломжтой зайгаар ажилладаг, ЗЦБ хийдэг/	ш	1
2.	Дефибриллятор/зөөврийн /AED	ш	1
3.	Зөөврийн отсос	ш	1
4.	Амьсгалын аппарат /зөөврийн/	ш	1
5.	Хүчилтөрөгчийн баллон 10 л	литр	1
6.	Амбу /нярай, хүүхэд, том хүн/	ш	1
7.	Ларингоскоп	ш	1
8.	Отоскоп	ш	1
9.	Глюкометр	ш	1
10.	Автомашины хог хаягдлын сав	ш	1
11.	Дамнуурга	ш	1
12.	Толгойн чиг	ш	1
13.	Хүзүүний чиг	ш	1
14.	Мөчдийн чиг	ш	1
15.	Нурууны чиг	ш	1
16.	Даралтын аппарат	ш	1
17.	Чагнуур	ш	1
18.	Пульсоксиметр	ш	1
19.	Цусны глюкоз хэмжигч	ш	1
20.	Судас гэрэлтүүлэгч	ш	1
21.	Мэдрэлийн алх	ш	1
22.	Мэс заслын хайч	ш	1
23.	Зүү баригч	ш	1
24.	Кохерын хавчуур	ш	2
25.	Бөөрөн таваг	ш	1
26.	Гар чийдэн	ш	1
27.	Зөөврийн цахилгаан үүсгүүр	ш	1
28.	Хөтөвч	ш	1
29.	Хүүхдийн амнаас салиа соруулах бургуй	ш	1
30.	Ходоодны зонд олон хэмжээст	ш	1
31.	Интубацийн гуурс	ш	1
32.	Бургуй тавих хэрэгсэл, хошууны хамт	ш	2
33.	Халуун, хүйтэн жин тавигч	ш	1

32.	Бургуй тавих хэрэгсэл, хошууны хамт	ш	2
33.	Халуун, хүйтэн жин тавигч	ш	1

Тайлбар:

1. Дээрхээс аппаратууд нь автомашины цахилгаан болон 220 вольтоор ажиллах боломжтой байна.
2. Түргэн тусламжийн автомашинд тавигдах шаардлага, түүнд байх тоног төхөөрөмжид MNS 6717:2018 стандартыг баримтална.

1.2. **Зайлшгүй шаардлагатай эм, тариа**

№	Эмийн олон улсын нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж/хэлбэр	Тоо хэмжээ
I. Өвдөлт намдаах эм				
1.	Морфин гидрохлорид	10мг/мл - 1 мл	ампул	2
2.	Трамадол гидрохлорид	100мг - 2 мл	ампул	2
3.	Метамизол натри	50% - 2 мл	ампул	4
4.	Ацетилсалицилын хүчил	500 мг	шахмал	10
5.	Диклофенак натри	50 мг - 3 мл	ампул	5
6.	Ацетаминофен	500 мг	шахмал	5
7.	Ацетаминофен	125 мг, 250 мг	лаа	5
8.	Налоксон	0.4мг / 1 мл	ампул	2
II. Хөдөлгөх мэдрэлд нөлөөлөх эм				
9.	Прозерин/ Неостигмин	0.5мг / мл	ампул	1
10.	Эпинефрин	1мг / мл	ампул	9
11.	Атропин сульфат	0.1% - 1 мл	ампул	2
III. Захын мэдрэлийн системд нөлөөлөх эм				
12.	Лидокаин	2% - 2 мл	ампул	2
13.	Новокаин	0.25% - 2 мл	ампул	4
IV. Тайвшруулах, сэтгэцэд нөлөөт эм, тариа				
14.	Диазепам	5 мг / мл	ампул	2
15.	Никетамид	25% - 1 мл	ампул	2
16.	Хлорпромазин	25 мг / мл	ампул	1
17.	Дроперидол	2.5 мг / мл	ампул	1
V. Зүрх судасны системд нөлөөлөх эм				
18.	Валидол	60 мг	шахмал	10
19.	Атенолол	25мг – 100мг	шахмал	10
20.	Глицерил тринитрат	5 мг	шахмал	10
21.	Амлодипин	10 мг	шахмал	10
22.	Изосорбид динитрат	5 мг	шахмал	2
23.	Амиодарон	150 мг/3мл	ампул	2
VI. Артерийн даралт бууруулах эм				
24.	Эналаприл	2.5 мг – 20 мг	шахмал	10
25.	Эналаприлат	12.5 мг	ампул	2
26.	Дибазол	1%-5мл	ампул	3
27.	Нифедипин	10мг	шахмал	10

VII.	***Уналт таталтын эсрэг эм***			
28.	Магнийн сульфат	25% - 10 мл	ампул	6
VIII.	***Гөлгөр булчингийн агчил тавиулах эм***			
29.	Дротаверин	20 мг / мл	ампул	2
IX.	***Цусны бүлэгнэлтэнд нөлөөлөх эм***			
30.	Викасол	1% - 1 мл	ампул	2
31.	Аминокапроны хүчил	40% - 10 мл	ампул	1
32.	Этамсилат	250 мг /2 мл	ампул	2
33.	Гепарин	5 мл, (1мл – 5000 ЕД)	флакон	1
X.	***Харшлын ба анафилаксийн эсрэг эм***			
34.	Дифенгидрамин	1% - 1 мл	ампул	4
35.	Цетиризин	10 мг	шахмал	10
36.	Хлорфенамин	4 мг	шахмал	10
XI.	***Шээлгэх үйлдэлтэй бэлдмэл***			
37.	Фуросемид	10 мг / мл	ампул	2
XII.	***Суулгалтын эсрэг эм***			
38.	Лоперамид	2 мг	шахмал	3
XIII.	***Бөөрний дайврын ба дааврын төст бэлдмэл***			
39.	Преднизолон	30 мг – 1 мл	ампул	2
40.	Дексаметазон	4 мг – 1 мл	ампул	2
XIV.	***Умайн булчинд нөлөөлөх эм***			
41.	Окситоцин	5 ЕД - 1 мл	ампул	2
XV.	***Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм***			
42.	Аминофиллин	24 мг / мл	ампул	2
43.	Сальбутамол	100 мкг	Ингаляцийн цацлага /фл/	1
XVI.	***Ионы тэнцвэрт нөлөөлөх эм***			
44.	Кальцийн глюконат	100 мг / мл	ампул	2
XVII.	***Бөөлжилтийн эсрэг эм***			
45.	Метоклопрамид	5 мг / мл	ампул	3
XVIII.	***Антибиотик***			
46.	Цефазолин	1 гр	флакон	2
47.	Синтомицины эмульс	5% - 15 гр	Флакон	1
XIX.	***Цусны сийвэн орлох ба хордлогын эсрэг эм***			
48.	Натрийн хлорид	0.9% - 2 мл	ампул	10
49.	Натрийн хлорид	0.9% - 500 мл	флакон	1
50.	Декстран	5% - 250 мл	флакон	3
51.	Декстран	40% - 10 мл	ампул	2
52.	Рингер-лактатын уусмал	250 мл , 500 мл	флакон	1
53.	Уулгаж сэлбэх олон найрлагат давсны бэлдмэл	29,7 гр	пач	2
54.	Идэвхижүүлсэн нүүрс	250мг	шахмал	1
XX.	***Түргэн тусламжид ашиглагдах бусад хэрэгсэл***			
55.	Тамедин	2.5% - 300 мл	фл	1

56.	Гар халдваргүйжүүлэх уусмал /спиртэн суурьтай/	100-500 мл	флакон	1
57.	Эмнэлгийн вазелин	20 гр	тюб	1
58.	Шээсний катетер	№ 14 – 16	ширхэг	2
59.	Үзлэгийн бээлий	ариутгаагүй	хос	5
60.	Мэс заслын бээлий	ариутгасан	хос	5
61.	Мэс заслын утас - Викриль /бөөрөнхий зүүтэй/	№ 0-3	ширхэг	1
62.	Мэс заслын утас - Викриль /гурвалжин зүүтэй/	№ 0-3	ширхэг	1
63.	Мэс заслын утас - Шёлк /бөөрөнхий зүүтэй/	№ 0-3	ширхэг	1
64.	Мэс заслын утас - Шёлк /гурвалжин зүүтэй/	№ 0-3	ширхэг	1
65.	Цусны систем		ширхэг	1
66.	Дуслын систем		ширхэг	5
67.	Тариур 20.0		ширхэг	5
68.	Тариур 10.0		ширхэг	10
69.	Тариур 5.0		ширхэг	10
70.	Тариур 3.0		ширхэг	10
71.	Тариур 1.0		ширхэг	10
72.	Нэг удаагийн зүү	22 , 23 G	ширхэг	20
73.	Уян зүү	24 G -18 G	ширхэг	3
74.	Амны хаалт	Эмнэлгийн нэг удаагийн хэрэглээний	ширхэг	10
75.	Амны хаалт	FFP2, FFP3 стандартын шүүлтүүртэй N95	ширхэг	5
76.	Вакум тенер		ком	2
77.	Жирэмсний тест		ширхэг	3
78.	Урометр	10 үзүүлэлтэй	ширхэг	3
79.	Нэг удаагийн хэл дарагч		ширхэг	10
80.	Мэс заслын хутга		ширхэг	1
81.	Эх барихын их бүрдэл	Нэг удаагийн	ком	1
82.	5 мм х 122 см урттай 12 хуруу гэдэс угаах гуурс		Полиэтилэн	1
83.	Ходоод угаах гуурс		ширхэг	1
84.	Нярайн хамраар хооллох гуурс 380 мм х 2,64 мм хэмжээтэй		ширхэг	1
85.	Салиа соруулагчийн хошуу		ширхэг	2
86.	Хүчилтөрөгчийн маск /том хүн/		ширхэг	1
87.	Хүчилтөрөгчийн маск /хүүхэд/		ширхэг	1
88.	Нярайн өлгий	ком	ширхэг	1
89.	Даавуу /нярай, дунд, өсвөр/	ком	ширхэг	1
90.	Дулаан алдуулахгүй бүтээлэг		ширхэг	1
91.	Ам арчигч		ширхэг	5
92.	Биеийн дулаан хэмжигч		ширхэг	1

93.	Мэс заслын гар угаах сойз		ширхэг	2
94.	Ясанд хатгах зүү /хүүхэд, том хүн/		ширхэг	1
95.	Хэл баригч		ширхэг	1
96.	Чангалуур		ширхэг	1
97.	Аюулгүй хайрцаг		ширхэг	1
XXI. Боолтын материал				
98.	Уян бинт	15*2м	ширхэг	5
99.	Бинт	7*14м	ширхэг	2
100.	Шарик /спирттэй хөвөн/	боодол	флакон	5
101.	Мэс заслын наалдамхай Пластер /хөндийрүүлэгчтэй/	25мм х 10м	ширхэг	2
102.	Цаасан наалт	2*3 м	ширхэг	2

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
а/75 тоот тушаалын гуравдугаар хавсралт

БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДАЛ, ОЛНЫГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕИЙН ЭРЭМБЭЛЛИЙН ЗААВАР

НЭГ. ЗОРИЛГО.

Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, олныг хамарсан осол гэмтлийн үед нэрвэгдэгсдэд газар дээр нь эмнэлгийн баг шуурхай арга хэмжээг нэн түрүүнд авахдаа амин үзүүлэлт, эмнэл зүйн шинж тэмдгийг үндэслэж эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх цаг хугацаа, цар хүрээний хувьд эрэмбэллийг тэргүүн эгнээнд хийснээр нас баралт хүндрэлээс сэргийлнэ.

ХОЁР. ЗОРИЛТ.

2.1. Эрэмбэлэл нь үйлчлүүлэгчийн өвчнийг оношлох бус биеийн байдлыг үнэлэхэд чиглэгдэнэ.
2.2. Эрэмбэлэл нь үйлчлүүлэгч олноор нэрвэгдсэн осол, гэмтэл, хордлого, бэртлийн үед цаг хугацаа болон нөөцийг хэмнэх зорилгоор хийгдэнэ.
2.3. Хурдан шуурхай эрэмбэлэх нь үйлчлүүлэгчийг эрт үеийн нас баралтаас сэргийлнэ.

ГУРАВ. ЭРЭМБЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ.

3.1. Цаг агаар, орчны эрсдэлт нөхцөл байдлыг үл харгалзан нэрвэгдэгсдийг эхлээд эрэмбэл,
3.2. Дараа нь яаралтай болон амилуулах тусламж үзүүл,
3.3. Тэгээд зөөвөрлөх буюу голомтоос гаргах,
3.4. Гэмтэж бэртсэн хүнийг эсрэг урсгалд бус, хөдөлгөөний чиглэл дагуу явуулах,
3.5. 1 осолдогчийг 1 минутын дотор үнэлж, эрэмбэлэх,
3.6. Эрэмбэллийн хуудсанд зөвхөн зөвлөх (√) байдлаар тэмдэглэлийг хийж, үйлчлүүлэгчийн биеийн нүдэнд ил үзэгдэх хэсэгт, эсвэл шархгүй бол баруун гарын шуунд зүүж тэмдэглэнэ.

ДӨРӨВ. ЭРЭМБЭЛЭЛ.

4.1. **Улаан карт буюу нэгдүгээр зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**
- Эгзэгтэй байгаа боловч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд сэргэх
- Их хэмжээний цус алдалт
- Пневмоторакс, хемоторакс
- Гавал тархины гэмтэл

4.2. **Шар карт буюу хоёрдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**
- Шарх ихтэй боловч түр азнаснаар амь насанд нь эрсдэл учрахгүй
- Биеийн байдал ноцтой өөрчлөгдөхгүй
- Дунд чөмөг, бугалгын хугарал гэх мэт

4.3. **Ногоон карт буюу гуравдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**

- Бага зэрэг шархтай, яаралтай бус
- Шархтай ч өөрөө явж байгаа
- Шалбархай, битүү бэртэл, үе булгарсан
- Шарх

4.4. **Хар карт буюу дөрөвдүгээр зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**

- Эмчилгээ хийсэн ч амьд гарах найдвар муутай
- Толгойдоо маш их гэмтэлтэй
- 3 дугаар зэрэглэлийн 95% -ийн түлэгдэлтэй
- Нас барсан

4.5. **Улбар шар карт буюу тавдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**

- Олон хүнийг хамарсан халдварт өвчин
- Өвчлөгсдийг яаралтай тусгаарлан, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан эмчилгээг холбогдох байгууллагад мэдэгдэн шуурхай зохион байгуулах.

ТАВ. ЭРЭМБЭЛЭХ ХУУДАС

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ЭРЭМБЭЛЭХ ХУУДАС.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН А/294 ТУШААЛ

ЗУРАГ 1

1 ДҮГЭЭР ЗЭРГИЙН НЭН ЯАРАЛТАЙ:	2 ДҮГЭЭР ЗЭРГИЙН ЯАРАЛТАЙ:	3 ДҮГЭЭР ЗЭРГИЙН ЯАРАЛТАЙ:
-Эгзэгтэй байгаа боловч эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сэргэх	-Шарх ихтэй боловч түр азнаснаар амь насанд нь эрсдэл учрахгүй	-Бага зэрэг шархтай, яаралтай бус
ШИНЖ ТЭМДЭГ:	**ШИНЖ ТЭМДЭГ:**	**ШИНЖ ТЭМДЭГ:**
-Их хэмжээний цус алдалт -Пневмоторакс -Гавал тархины гэмтэл -Бусад цээжний гэмтлүүд	-Биеийн байдал ноцтой өөрчлөхдөхгүй -Дунд чөмөг, бугалганы хугарлын үед	-Шархтай ч өөрөө явж байгаа -Шалбархай, битүү бэртэл, үе булгарсан -Өнгөц шарх

ЗУРАГ 2.

Тийм	Үгүй	Анхдагч халдваргүйтгэл
Тийм	Үгүй	Хоёрдогч халдваргүйтгэл
Гэмтлийн төрөл:		
	Битүү гэмтэл	
	Түлэгдэл	
	Хүзүүний нугалмын гэмтэл	
	Зүрхний гэмтэл	
	Удаан дарагдалт	
	Хугарал	
	Шалбаралт	
	Нэвтэрсэн гэмтэл	

Амин үзүүлэлтүүд			
Цаг	Цусны даралт	Судасны лугшилт	Амьсгалын тоо
Цаг	Эмийн эмчилгээ		Тун

4 ДҮГЭЭР ЗЭРГИЙН ЯАРАЛТАЙ:

Найдваргүй өвчтөн эмчилгээ хийсэн ч амьд гарах найдвар муутай.
Толгойдоо маш их гэмтэлтэй 3 дугаар зэрэглэлийн 95%-н түлэгдэлтэй

ОЛОН ХҮНИЙГ ХАМАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН:

-Өвчлөгсдийг яаралтай тусгаарлан, халдвар хамгаалалын дэглэмийг нарийн чанд баримтлан эмчилнэ.
-Зооноз, АЦХаХ

Тэмдэглэл:

_____
_____
_____
_____
_____
_____
_____
_____

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
а/75 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТҮРГЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРГЭН МЭДЭЭЛЭХ ТАЙЛАНГИЙН МАЯГТ

1.1. Түргэн тусламжийн дуудлагын тоо

№	Үзүүлэлт			№	Өрх, сумын эрүүл мэндийн төв	БОЭТ	Нийт
1	Хүүхэд	0-5 насны хүүхдийн томуу, амьсгалын замын өвчлөл		1.			
		Хордлого		2.			
		Халдварт өвчин		3.			
2	Насанд хүрэгчид	Осол гэмтэл	Архи	4.			
			Хоол	5.			
		Төрөх		6.			
		Халдварт өвчин		7.			
		Бусад		8.			
3	Түргэн тусламжийн дуудлагад тохиолдсон нас баралт			9.			

1.2. Орон нутагт гарсан олныг хамарсан аюулд өртсөн хүний тоо

№	Үзүүлэлт	№	Өрх, сумын эрүүл мэндийн төв	БОЭТ	Нийт
1	Осол, гэмтэл	1.			
	Хордлого	2.			
	Түлэгдэлт	3.			
	Үер, усны аюул	4.			
	Нас баралт	5.			
	Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол	6.			